



БОДЛОГЫН ОРОН ЗАЙН ИНДЕКС

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Боловсруулсан: Судалгааны багийн ахлагч Б.Түвшинтөгс

Судалгааны багийн гишүүд: З.Манлайбаатар

Б.Мөнх-Ирээдүй

Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн судлаачийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

1. ОРШИЛ

Энэхүү судалгаа Монголын эдийн засагт сүүлийн жилүүдэд явагдсан хурдацтай өсөлт тогтвортой эсэх, “хэт халалт” (overheating) бий болгож байгаа эсэх, энэ үед эдийн засагт сөрөг цочрол тохиолдвол макро эдийн засгийн хариу арга хэмжээ авах орон зай (wiggle room) бий эсэхэд бодитой үнэлэлт өгөх зорилготой эхэлсэн. Эдийн засгийн хэт халалтын индекс, Бодлогын орон зайн индекс тооцох аргачлалуудыг Economic Intelligence Unit байгууллагаас боловсруулан, улс орнуудыг харьцуулсан байдаг (Economic Intelligence Unit, 2012). Бид судалгаандаа эдгээр аргачлалыг ашиглаж байгаа (аргачлалын талаар Хавсралт 1-ээс үзнэ үү) бөгөөд Монголын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, бусад шаардлагатай мэдээллийг Сангийн яам, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк, Олон улсын валютын сан гэх мэт төрийн ба олон улсын байгууллага, судалгааны төвүүдийн хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа, тайлангаас түүвэрлэн авсан.

Эдийн засгийн хурдацтай өсөлтийг дагаад нийт эрэлтийн огцом өсөлт явагдаж, улмаар эдийн засагт “хэт халалт” (overheating) бий болдог. Эдийн засаг хэт халсан үед засгийн газар илүүдэл нөөцийг хуримтлуулж, харин уналт ирэх үед уг нөөц боломжоор эдийн засгаа дэмжиж, эдийн засгийнхаа мөчлөгийг дагах биш, мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх ёстой. Гэтэл Монголын эдийн засгийн бодлого сүүлийн 18 жилийн турш мөчлөг дагасан, тэр ч байтугай мөчлөгийн хэлбэлзлийг улам савлуулах шинжтэй явж ирснийг Зураг 1 дэх эдийн засгийн үзүүлэлтүүд харуулж байна. Ялангуяа, сангийн бодлогод ийм шинж илэрхий байгаа юм. Мөнгөний бодлогын хувьд ч сүүлийн үед мөчлөг дагасан шинж тод ажиглагдаж байна.

Зураг 1. ДНБ, төсөв, мөнгөний нийлүүлэлтийн нэрлэсэн өөрчлөлт (%)



Эх сурвалж: (Үндэсний Статистикийн Хороо, 1998-2014)

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсноор эдийн засагт тохиолдож болох эрсдэлийг урьдчилан таамаглах боломж бүрдэнэ. Бид энэ судалгаагаар Монголын эдийн засгийн “хэт халалтын” эрсдэл ба мөчлөг сөрөх бодлогын орон зайг үнэлж, сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж буй орнуудынхтай харьцуулах юм.

Энэхүү судалгаагаар Монголын эдийн засгийн хэт халалт ба бодлогын орон зайн индексийг 2008 оноос 2015 оны 2-р улирал хүртэл тооцлоо. Мөн эдийн засгийн хэт халалт болон бодлогын орон зайн үзүүлэлтийг 2012 оноос өмнөх онуудад эрчимтэй хөгжиж буй болон уул уурхайн бүтээгдэхүүн голлон экспортлодог 30 оронтой харьцуулав. Харин тоон мэдээллийн олдоцтой холбоотойгоор эдийн засгийн хэт халалтын харьцуулалтыг 2014 онд 22 оронтой, бодлогын орон зайн харьцуулалтыг 2013 оны хувьд 26 орныхтой, 2014 оны хувьд 22 орныхтой харьцуулан харууллаа.

Тус тайлангийн хоёрдугаар бүлэгт эдийн засгийн хэт халалтын болон бусад эрсдэл ямар түвшинд байгааг харуулах эдийн засгийн хэт халалтын индекс Монголын эдийн засгийн хувьд сүүлийн 8 жилд хэрхэн өөрчлөгдөж ирснийг улирал бүрээр нарийвчлан тооцов. Мөн Монголын эдийн засгийн хэт халалтын индекс бусад хөгжиж буй орны үзүүлэлтээс ямар түвшинд байгааг 2014 оны байдлаар харьцуулав. Гуравдугаар бүлэгт эдийн засгийн мөчлөг уналтын эрсдэлд улс орны бодлого боловсруулагчид хэр бэлэн байгааг харуулах бодлогын орон зайн индекс сүүлийн 8 жилд хэрхэн өөрчлөгдсөнийг улирал бүрээр нарийвчлан тооцов. Улмаар Монголын эдийн засгийн бодлогын орон зай бусад хөгжиж буй орны үзүүлэлтээс ямар түвшинд байгааг харьцуулсан. Эцэст нь, эдийн засгийн халалтын эрсдэл ба бодлогын орон зайн талаар товч дүгнэлт өгөв.

2. ХЭТ ХАЛАЛТЫН ЭРСДЭЛ


2.1. Монголын эдийн засгийн хэт халалтын үзүүлэлт

Тухайн улсын үйлдвэрлэлийн хүчин чадал нийт эрэлтийнхээ хурдтай өсөлтийг гүйцэхгүй болсон үед эдийн засаг халж эхэлдэг. Ийм үед үйлдвэрлэгчид нөөцийг хэт дайчлан илүүдэл үйлдвэрлэл явуулдаг. Үр дүнд нь ажилгүйдэл эрс багасах сайн талтай боловч үнэ өсөх, гадаад тэнцэл алдагдах зэргээр эдийн засаг тогтворгүй болдог. Эдийн засгийн хэт халалтыг хэмжих нэг индексийг 2012 онд The Economist сэтгүүл боловсруулж, хурдтай хөгжиж буй зарим орны эдийн засагт үнэлэлт өгсөн байдаг (Economic Intelligence Unit, 2012). Энэхүү индексийг тооцох аргачлалыг бид нарийвчлан боловсруулж Хавсралт 1-д тайлбарлалаа.

Эдийн засгийн халалтын индекс нь инфляци, бодит хүү, урсгал тэнцэл, илүүдэл зээл, эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл гэсэн 6 гол үзүүлэлтийг тус бүр ижил жинтэйгээр авч үздэг. Тухайлбал, инфляци өндөр, бодит хүү маш бага, урсгал тэнцлийн алдагдал их, илүүдэл зээлийн өсөлт хурдан, эдийн засгийн өсөлт хэт өндөр, ажилгүйдэл хэвийн түвшнээсээ хэт доогуур байвал эдийн засаг халж байна гэж үзнэ.

Монголын эдийн засгийн халалт 2008 оноос хойш хэрхэн өөрчлөгдөж ирснийг улирал бүрээр Зураг 2-т харуулав. Уг индексийн утга 100-д дөхөх тусам хэт халж байна гэж үзэх ба харин 0-д ойртох тусам халалт багатай гэж үзнэ.

Зураг 2. Монголын эдийн засгийн хэт халалтын индекс



Эх сурвалж: Монголбанк, (Сарын бюллетень, 2007-2014), (Төлбөрийн тэнцэл, 2007-2015), (Мөнгөний статистикийн тойм, 2007-2015), Үндэсний Статистикийн Хороо (Сарын бюллетень, 2007-2015)

Дээрх зургаас үзвэл, 2008 онд Монголын эдийн засаг маш хүчтэй халж байснаа дэлхийн санхүүгийн хямралтай зэрэгцэн хурдтай хөрч, 2009 оны 4-р улиралд хамгийн бага түвшиндээ очжээ. Гэхдээ энэ байдал удаан үргэлжлээгүй бөгөөд эдийн засгийн халалт аажим нэмэгдсээр 2011 оны 3-р улирал гэхэд санхүүгийн хямралын өмнөх түвшинд дөхөн очсон. Түүнээс хойш 2 жилийн турш бага зэрэг хэлбэлзэж байгаад 2014 оноос хойш уг индекс эрс буурч байна. Монголын эдийн засгийн хэт халалтын индексийг Хавсралт 1 дэх аргачлалын дагуу улирал бүрээр тооцсон үр дүнг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Монголын эдийн засгийн хэт халалтын индекс, хувиар

Улирал	Инфляци	Бодит хүү	Урсгал тэнцэл/ДНБ	Зээлийн илүүдэл өсөлт	ДНБ-ий зөрүү	Ажилгүйдлийн зөрүү	Хэт халалтын индекс	
2008	I	20.6	1.7	0.8	47.1	1.8	-0.7	75
	II	32.4	0.3	-3.1	33.0	1.9	-0.8	83
	III	31.7	-0.3	-7.0	17.6	4.0	-1.0	100
	IV	23.2	-0.7	-12.1	3.3	3.1	-0.8	83
2009	I	17.2	2.8	-13.0	-4.6	-0.9	0.4	42
	II	4.7	15.2	-12.4	-14.6	-3.0	0.2	25
	III	-1.9	18.4	-9.9	-17.9	-7.0	-0.1	25
	IV	1.9	20.6	-7.5	-15.4	-7.4	0.1	17
2010	I	7.8	18.3	-8.2	-10.5	-3.8	0.2	33
	II	12.6	9.5	-7.6	-8.5	0.2	0.0	58
	III	10.9	4.2	-9.0	-10.0	3.9	-0.2	75
	IV	14.3	-2.5	-13.8	-9.0	0.8	0.0	58
2011	I	10.8	-3.9	-17.3	-4.4	2.3	1.8	67
	II	11.7	-5.9	-22.2	15.5	0.0	1.7	67
	III	11.8	-3.4	-29.7	34.8	2.2	1.7	83
	IV	14.3	2.7	-31.4	52.1	11.2	1.8	75
2012	I	14.4	3.1	-34.2	42.8	6.9	-0.2	75
	II	15.7	8.1	-32.9	21.8	11.7	-0.3	75
	III	16.6	6.9	-34.2	12.9	8.4	-0.4	75
	IV	15.5	1.9	-31.8	-1.1	4.8	-0.1	67
2013	I	9.8	6.4	-30.7	0.0	4.3	0.5	58
	II	8.8	5.9	-31.1	11.5	2.0	0.1	67
	III	9.9	6.9	-26.9	18.5	3.0	0.3	67
	IV	12.5	4.0	-26.4	27.6	2.9	0.4	67
2014	I	12.4	4.1	-22.7	24.2	1.8	-0.3	75
	II	14.6	4.0	-20.4	18.7	-0.5	-0.3	67
	III	13.0	1.7	-15.7	-0.9	-1.7	-0.4	50
	IV	11.0	6.7	-11.4	-9.1	-2.4	-0.1	50
2015	I	9.3	13.1	-7.6	-4.1	-2.7	-0.5	42
	II	7.3	15.3	-5.1	-12.4	-3.6	-0.5	42

Эх сурвалж: Монголбанк (Сарын бюллетень, 2007-2015), (Төлбөрийн тэнцэл, 2007-2015), (Мөнгөний статистикийн тойм, 2007-2015), Үндэсний Статистикийн Хороо (Сарын бюллетень, 2007-2015)

Дээрх хүснэгтээс харвал, эдийн засаг сүүлийн жилд хүчтэй хөрч буйн гол шалтгаан нь:

- Зээлийн илүүдэл өсөлт буурсан буюу банкуудаас хувийн хэвшилд олгосон зээлийн өсөлт буурч, нэрлэсэн ДНБ-ий өсөлтийг гүйцэхгүй болсон
- ДНБ-ий өсөлт өмнөх 10 жилийн дунджаас удааширсан
- Урсгал тэнцлийн алдагдал бага боловч буурч байгаа зэрэгтэй холбоотой байна.

Харин ажилгүйдлийн түвшин олон жилийн дунджаас ялимгүй доогуур гарах болсон нь эдийн засгийн “хөрөлт”-ийг бага зэрэг сааруулж байна. Бид энэ судалгаанд олон улсын өгөгдөлтэй харьцуулагдах боломж, олон жил тогтвортой ашиглан тооцож буй аргазүйг нь харгалзан Хөдөлмөрийн яамны тооцож буй ажилгүйдлийн үзүүлэлтийг сонгож авсан.

2.2. Эрчимтэй хөгжиж буй орнуудын хэт халалтын үзүүлэлт


Дээрх шинжилгээг өргөтгөж, Монголын эдийн засгийн 2014 оны хэт халалтын үзүүлэлтийг эрчимтэй хөгжиж буй болон уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч 22 орны үзүүлэлттэй харьцуулъя. Зураг 3-т эдгээр орны эдийн засгийн халалтын түвшинг 2009-2013 оны түвшинтэй зэрэгцүүлж харуулав. Одоогоор 2013, 2014 оны зарим орны тоон мэдээлэл бүрэн гараагүй учраас судалгаанд хамрагдах орны тоо зөрөөтэй байгаа. Доорх зурагт улсуудыг халалтын түвшингээр нь багаас их рүү эрэмбэлсэн. Өөрөөр хэлбэл, тухайн жилд эдийн засаг нь халалт багатай байсан орнууд зургийн дээд хэсэгт, эдийн засаг нь их халсан орнууд зургийн доод хэсэгт дүрслэгдсэн. Зурагт ашигласан 2009-2014 оны дэлгэрэнгүй өгөгдлийг Хавсралт 2-т хавсаргалаа.

Зургаас харахад, сонгосон орнуудын эдийн засаг 2009 онд огцом хөрч, 2010-2011 онд эргээд халж, 2012 онд бага зэрэг хөрчээ. Харин 2013 онд улс бүрийн эдийн засагт хэт халалт ажиглагдсан боловч 2014 онд нэлэнхүйдээ эргээд огцом хөрч байна. Эдгээр орноос Аргентиний эдийн засаг хамгийн их халалттай орон хэвээр үлджээ. Мөн Венесуэл, Колумб, Бразил гэх мэт Латин Америкийн түүхий эд экспортлогч орнуудын эдийн засаг халалт ихтэй орнуудын тоонд орж байна. Харин Монголын эдийн засаг 2012, 2013 онд эдийн засаг нь хамгийн их халсан орон байсан бол 2014 онд огцом хөрч, Австралитай зэрэгцжээ. Эдгээр орны хувьд өнгөрсөн хугацаанд ихэвчлэн инфляци ихтэй, улмаар бодит хүү нь сөрөг, эсвэл урсгал тэнцэл алдагдалтай, ажилгүйдэл нь олон жилийн дунджаасаа нэлээд доогуур байжээ.

Уул уурхайн түүхий эд экспортлогч орнуудаас 2014 онд эдийн засаг нь харьцангуй их халсан орны тоонд Чили, Индонези, Орос орж байгаа бол эдийн засгийн халалт багатай орны тоонд Австрали, Норвеги зэрэг улс орсон хэвээр байна. Энэ нь байгалийн баялгийн орлогын менежмент сайтай орнууд түүхий

эдийн үнийн өсөлтийг дагалдан гардаг эдийн засгийн хэт халалтын эрсдэлд бага өртдөгийг харуулж байна.

Зураг 3. Хөгжиж буй орнуудын Эдийн засгийн халалт, 2009-2014 он



Эх сурвалж: (World Bank, 2015), (IMF, 2014), (BIS, 2014), Зарим орны Төв банкны Сар тутмын бюллетень

Шилжилтийн эдийн засагтай гэгдэж байсан Чех, Азербайжан зэрэг орны эдийн засгийн халалт маш бага байгаа юм. Мөн хүчтэй аж үйлдвэржиж байгаа Азийн бар орнуудын эдийн засгийн халалт харьцангуй бага хэвээр байна.

Монголын эдийн засгийн хувьд 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын үеэр нэлээд “хөрч” байсан боловч сүүлийн жилүүдэд огцом халж, хамгийн их халсан эдийн засгийн нэгд орж байсан. Харин 2014 онд сонгосон орнуудын эдийн засаг бараг бүгд “хөрсөн” бөгөөд тэр дундаа Монголын эдийн засаг хамгийн хүчтэй хөрчээ.

Шигтгээ 1. Аргентины эдийн засгийн хэт халалт

Сүүлийн жилүүдэд хамгийн их халж байгаа Аргентины эдийн засаг 2003-2011 онд жилд дунджаар 7.1 хувиар өсчээ (World Bank, 2014). Энэ хурдтай өсөлт юуны өмнө тус улсын хөдөө аж ахуйн түүхий эдийн үнэ өссөн, тэр дундаа экспортын голлох бүтээгдэхүүн болох шар буурцгийн үнэ гурав дахин өссөнтэй холбоотой юм. Үүнээс гадна тус улсын экспортын гол түнш орнууд болох Хятад, Бразилийн эдийн засгийн өсөлт чухал нөлөө үзүүлжээ. Хятад улс Аргентины шар буурцгийн экспортын 90 хувийг импортолдог бөгөөд хөдөө аж ахуйн дэд бүтцийг нь хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулжээ. Харин Бразил улс Аргентинаас суудлын авто машин, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ихээр импортолдог.

Гэхдээ энд Аргентины эдийн засгийн хурдтай өсөлт хэр тогтвортой вэ гэдэг хамгийн гол асуудал байсан. Эдийн засгийн өсөлт тогтворгүй, найдваргүй байгаа эрсдэлийг харуулах үзүүлэлт нь “эдийн засгийн хэт халалтын индекс” гэж хэлж болно. Хэт халж байсан Аргентины эдийн засгийн өсөлт сүүлийн хоёр жилд эрс саарч, 2012 онд дөнгөж 0.95 хувь, 2013 онд 2.95 хувь болоод байгаа нь үүний жишээ юм.

Үүний шалтгааныг хэд хэдэн хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно. Юуны өмнө экспортын огцом өсөлтөөр валютын нөөц, экспортын татварын орлого нь үлэмж нэмэгдсэн тус улсын засгийн газар нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн санхүүжилтээ нэмэгдүүлсэн. Мөн эрчим хүч, тээвэр, хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуйд их хэмжээний татаас олгох болсон. Ингэснээр засгийн газрын зардлын ДНБ-д эзлэх хувь 2003 онд 30.4 хувь байсан бол 2013 онд 46 хувь болж өсчээ (IMF, 2014).

Тус улсын хувьд өөр нэг тулгамдсан асуудал бол сүүлийн жилүүдэд байнга хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх түвшинд хурдасч байгаа үнийн өсөлт юм. Инфляци орлого багатай иргэдийн амьдралд хүндээр тусч байна. Мөн хүмүүсийн хэрэглэх хандлагыг нэмж хуримтлал хийх, хөрөнгө оруулах сонирхлыг бууруулжээ. Тухайлбал, ДНБ-ий 4.6 хувь хүрч байсан нийт хуримтлал 2012 онд буурч -3.9 хувь (сөрөг хуримтлал) болжээ (World Bank, 2014). Өндөр инфляцийн улмаас зээлийн дундаж хүү өсч, 2014 оны хагас жилийн байдлаар жилийн 25 хувьд хүрээд байна (IMF, 2014b). Гадаадын шууд цэвэр хөрөнгө оруулалт ихээр буурах болсон. 2005 онд энэ үзүүлэлт 3.9 тэрбум ам.долларын алдагдалтай байсан бол 2012 онд 11 тэрбум ам.долларын алдагдалтай гарчээ.

Эдийн засгийн хэт халалт нь ерөнхийдөө огцом хурдтай өсч байгаа эдийн засагт ажиглагддаг үзэгдэл. Гэхдээ эдийн засаг хурдтай өсч байгаа нөхцөлд төсөв илүүдэлтэй гарч байх ёстой. Гэтэл Монголын хувьд тийм биш байгаа нь засгийн газар мөчлөг дагасан үйл ажиллагаа явуулж байгаагийн нэг нотолгоо юм. Ийм нөхцөлд хүүг өсгөх, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах гэх мэтээр мөнгөний бодлогыг чангаруулах, төсвийн алдагдлыг багасгах, өрийг багасгах гэх мэтээр сангийн бодлогыг хумих шаардлагатай байдаг. Үүнээс үүдээд, мөчлөгийн уналт тохиолдох үед Засгийн газар, Төв банк бодлогын маневр хийх боломж хэр байгаад бодитой үнэлэлт өгөх шаардлага урган гарч байна. Монголын эдийн засагт бодлогын хариу арга хэмжээ авах чадвар хэр байгааг Бодлогын орон зайн индексийн тусламжтайгаар дараагийн бүлэгт нарийвчлан авч үзнэ.

3. БОДЛОГЫН ОРОН ЗАЙ

3.1. Монголын эдийн засгийн бодлогын орон зайн өөрчлөлт

Монголын эдийн засаг сүүлийн жилүүдэд маш хүчтэй халж байгаад 2014, 2015 онд огцом “хөрч” байгааг Эдийн засгийн хэт халалтын индекс харуулж байна. Ийм нөхцөлд Монголын бодлого боловсруулагчид эдийн засгийн бодлогоо тохируулан өөрчлөх орон зай хэр байгаа вэ? Үүнд хариулахын тулд энэ бүлэгт Монголын эдийн засгийн бодлогын орон зай сүүлийн жилүүдэд хэрхэн өөрчлөгдөж ирснийг үнэллээ.

Эдийн засагт ямар нэг цочир өөрчлөлт тохиолдвол өрх гэрүүд хэрэглээгээ, бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалтаа өөрчлөх замаар хариу үйлдэл үзүүлэхдээ ихэвчлэн уг хэлбэлзлийг улам хүчтэй савлуулах хандлагатай байдаг. Ийм үед засгийн газар уг мөчлөгийг сөрж тогтворжуулах бодлого хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нөөц бололцоо буюу орон зай шаардлагатай. Хэлбэлзэл харьцангуй бага байх үед хариу арга хэмжээг эрт авах тусам бодлого үр дүнтэй болно. Харин бодлогын орон зай хязгаарлагдмал байсны улмаас хариу арга хэмжээ авч чадалгүй удвал нөхцөл байдал улам хүндэрч, эдийн засгийн хямрал нүүрлэх аюултай

Эдийн засгийн бодлогын орон зайг сангийн ба мөнгөний бодлогын хүрээнд ялгаж авч үзэж болно. Сангийн бодлогын орон зай нь эдийн засаг уналтад орсон үед эдийн засгийг сэргээхийн тулд төсвийн зардлыг нэмэх, бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт мөчлөгийн эсрэг арга хэмжээ авах бололцоо хэр байгааг харуулна. Мөнгөний бодлогын орон зай нь эдийн засгийн уналт тохиолдоход тухайн улс мөнгөний бодлогоо сулруулан мөчлөгийг сөрж чадах бололцоо хэр байгааг илэрхийлнэ.


Эдийн засгийн мөчлөгийн уналтыг сөрөх боломж хэр байгааг харуулсан Бодлогын Орон Зайн Индексийг 2012 онд The Economist сэтгүүл боловсруулж,

хурдтай хөгжиж буй зарим орны эдийн засагт үнэлэлт өгсөн байдаг (Economic Intelligence Unit, 2012). Энэхүү индексийг тооцох аргачлалыг бид нарийвчлан боловсруулж Хавсралт 1-д тайлбарласан. Бодлогын орон зайн индекс нь сангийн ба мөнгөний бодлогын орон зайд ижил ач холбогдол өгч, сангийн бодлогын орон зайг төсвийн тэнцэл (ДНБ харьцаа ба улсын өр) ДНБ харьцаа гэсэн хоёр үзүүлэлтээр хэмжих бол мөнгөний бодлогын орон зайг инфляци, бодит хүү, урсгал тэнцэл (ДНБ харьцаа, илүүдэл зээлийн өсөлт), валютын ханшийн өөрчлөлт гэсэн таван үзүүлэлтээр хэмжинэ. Инфляци их, бодит хүү маш доогуур, хувийн хэвшилд олгосон банкны зээлийн нийлүүлэлт үйлдвэрлэлийн өсөлтөөс илүү, үндэсний валютын ханш их унасан, урсгал тэнцэл байнгын алдагдалтай байвал мөнгөний бодлогын орон зай нь хумигдана. Мөн төсвийн алдагдал их, засгийн газрын гадаад, дотоод өр их байгаа үед эдийн засгийн уналтын эсрэг сангийн бодлого хэрэгжүүлэхэд хэцүү болно.

Бодлогын орон зайн индекс их утгатай байх нь тухайн улсын эдийн засгийн бодлогын орон зай хязгаарлагдмал байгааг харуулна. Индексийн хамгийн их утга 100 байх ба энэ нь бодлогын орон зайгүй болсныг харуулах бол индексийн утга 0 байвал бодлогын хангалттай орон зай байгааг харуулна.

Монголын эдийн засгийн бодлогын орон зайн индексийн 2008 оноос хойшхи улирал бүрээр хийсэн тооцоог Зураг 4-т харуулав.

Зураг 4. Монголын эдийн засгийн бодлогын орон зайн индекс



Эх сурвалж: Монголбанк, (Сарын бюллетень, 2007-2015), (Төлбөрийн тэнцэл, 2007-2015), (Мөнгөний статистикийн тойм, 2007-2015), Үндэсний Статистикийн Хороо (Сарын бюллетень, 2007-2015)

Зургаас харахад, Монгол дахь эдийн засгийн бодлогын орон зай 2008 оны сүүл үеэс эрс хумигдсан бөгөөд эдийн засаг хөрч эхэлсэн 2009 оны үед ч хязгаарлагдмал хэвээр үлджээ. Түүнээс хойш бодлогын орон зай улам хязгаарлагдсан байна. Хэдийгээр 2014 оны сүүлийн хоёр улиралд бодлогын орон зай ялимгүй нэмэгдсэн боловч эдүгээ маш эрсдэлтэй хэвээр байна. Зургаас анзаарагдах нэг сонирхолтой зүйл бол мөнгөний бодлогын орон зай (цэнхэр муруй) ба сангийн бодлогын орон зай (улаан муруй) эсрэг чиглэлд өөрчлөгдөж буй явдал юм. Тухайлбал, мөнгөний бодлогын орон зай бага зэрэг тэлэх үед сангийн бодлогын орон зай хумигдаж, харин сангийн бодлогын орон зай тэлж эхлэх үед мөнгөний бодлогын орон зай хумигдаж иржээ.

Бодлогын орон зай улам бүр хязгаарлагдах болсны шалтгааныг Хүснэгт 2-т үзүүлэлт тус бүрээр нарийвчлан харуулав.

Хүснэгт 2. Монголын эдийн засгийн бодлогын орон зайн индекс, хувиар

Улирал	Инфляци	Мөнгөний бодлого					Сангийн бодлого			Бодлогын орон зайн индекс
		Бодит хүү	Урсгал тэнцэл / ДНБ	Зээлийн илүүдэл өсөлт	Валогын ханшийн өөрчлөлт	Төсвийн тэнцэл / ДНБ	Засгийн газрын өр / ДНБ			
2008	I	20.6	1.7	0.8	47.1	0.2	23.6	30.7	30	
	II	32.4	0.3	-3.1	33.0	0.7	19.1	30.7	40	
	III	31.7	-0.3	-7.0	17.6	0.9	11.6	30.7	45	
	IV	23.2	-0.7	-12.1	3.3	-2.1	-4.6	30.7	65	
2009	I	17.2	2.8	-13.0	-4.6	-22.8	-10.6	43.8	68	
	II	4.7	15.2	-12.4	-14.6	1.2	-20.9	43.8	58	
	III	-1.9	18.4	-9.9	-17.9	-0.9	-36.2	43.8	53	
	IV	1.9	20.6	-7.5	-15.4	0.1	-43.1	43.8	53	
2010	I	7.8	18.3	-8.0	-14.0	0.8	-40.9	43.3	63	
	II	12.6	9.5	-7.0	-17.5	3.1	-36.7	43.3	63	
	III	10.9	4.2	-8.1	-24.4	3.2	-24.5	43.3	68	
	IV	14.3	-2.5	-12.0	-28.7	5.0	-9.2	43.3	68	
2011	I	10.8	-3.9	-14.8	-21.5	2.0	-5.5	44.9	73	
	II	11.7	-5.9	-19.0	3.9	0.7	1.9	44.9	65	
	III	11.8	-3.4	-25.3	27.8	-0.9	7.7	44.9	58	
	IV	14.3	2.7	-26.6	49.1	-6.5	0.5	44.9	70	
2012	I	14.4	3.1	-29.3	42.8	-2.0	0.0	44.9	60	
	II	15.7	8.1	-28.5	23.5	2.7	-8.0	44.9	68	
	III	16.6	6.9	-29.8	16.1	-3.6	-21	44.9	73	
	IV	15.5	1.9	-27.8	2.9	-1.9	-30.4	63.7	80	

2013	I	9.8	6.4	-27.1	4.2	-0.3	-28.5	64.3	80
	II	8.8	5.9	-28.2	17.0	-2.4	-21.0	64.3	85
	III	9.9	6.9	-25.0	25.8	-9.6	-13.4	64.3	90
	IV	12.5	4.0	-25.3	38.7	-8.3	-3.1	64.3	78
2014	I	12.4	4.1	-23.4	34.1	-2.8	-5.7	57.6	85
	II	14.6	4.0	-22.1	24.1	-3.5	-8.4	57.6	85
	III	13.0	1.7	-18.1	4.6	-2.2	-8.4	57.6	80
	IV	11.0	6.7	-11.5	1.9	-1.3	-12.7	57.6	80
2015	I	9.3	13.1	-7.6	-4.1	-6.1	-12.7	59.1	80
	II	7.3	15.3	-5.1	-12.4	4.1	-15.5	59.1	70

Эх сурвалж: Монголбанк (Сарын бюллетень, 2007-2015), (Төлбөрийн тэнцэл, 2007-2015), (Мөнгөний статистикийн тойм, 2007-2015), Үндэсний Статистикийн Хороо (Сарын бюллетень, 2007-2015), (Засгийн газар, 2015)

Дээрх хүснэгтээс харвал Монголын эдийн засгийн бодлогын орон зай сүүлийн жилүүдэд маш их хязгаарлагдах болсны гол шалтгаан нь:

- Засгийн газрын нэмэгдэж буй өр¹
- Төсвийн байнгын алдагдал
- Өндөр инфляци
- Урсгал тэнцлийн их хэмжээний алдагдал
- Нэрлэсэн ДНБ-ий өсөлтөөс давж буй хувийн хэвшилд олгосон зээлийн өсөлт
- Төгрөгийн ханшийн сулралт зэрэг болно.

Гэхдээ сүүлийн хоёр улиралд инфляци, урсгал тэнцлийн алдагдал эрчимтэй буурч, хувийн хэвшилд олгосон зээлийн өсөлт саарч, төгрөгийн ханш бага зэрэг чангарсан нь бодлогын орон зай бага зэрэг тэлэхэд нөлөөлж байна.

Мөн инфляци ихтэй үед ч бодит хүү ихэвчлэн эерэг утгатай байж ирсэн нь бодлогын орон зайн хязгаарлалтыг бага боловч сулруулж байгаа юм. Энэ нь хүчтэй уналт тохиолдсон үед Монголбанк бодлогын хүүг бууруулах замаар бодит хүүг бууруулж, эрэлтийг дэмжих бололцоо хадгалагдаж байгааг харуулна.

3.2. Эрчимтэй хөгжиж буй орнуудын бодлогын орон зай

Монголын эдийн засгийн 2009-2012 оны бодлогын орон зайн динамикийг эрчимтэй хөгжиж буй болон уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч 30 гол орны үзүүлэлттэй харьцуулсан. Харин улс орнуудын харьцуулагдах мэдээллийн олдцоос шалтгаалан 2013 оны хувьд 26 орноор, 2014 оны хувьд 22 орноор харьцуулан доорх зурагт харуулав. Энэхүү тооцоонд улс орнуудын сангийн


¹ 2014, 2015 оны өрийн тоо мэдээллийг 2015 оны 10-р сард Засгийн газраас УИХ-д 2016 оны төсвийн хэлэлцүүлэгт өргөн барьсан дэлгэрэнгүй танилцуулгаас авлаа. Өрийн харьцаа 55 хувиас давсан тохиолдолд уг үзүүлэлтэд харгалзах орон зайн индекс хамгийн их утгаа авдаг.


бодлоготой холбоотой үзүүлэлтүүд буюу төсвийн алдагдал ба засгийн газрын өрийн мэдээлэл бүрэн шинэчлэгдээгүй байсан тул 2012 оны үзүүлэлтүүдийг хэвээр нь сонгож авсан.

Тухайн жилд бодлогын орон зай ихтэй байсан орнуудыг зургийн дээд хэсэгт, бодлогын орон зай багатай болсон орнуудыг зургийн доод хэсэгт дүрслэв. Эдгээр улсын бодлогын орон зайн индексийн тооцоонд ашигласан дэлгэрэнгүй тоон мэдээллийг Хавсралт 3-г харуулав.

Зургаас харахад, сонгосон орнууд дунд бодлогын орон зай хамгийн муутай нь Энэтхэг, Египет, Пакистан, Аргентин, Венесуэл байсан бөгөөд Монголын индекс жил дараалан муудсаар 2012, 2013 онд бодлогын орон зай хамгийн хязгаарлагдмал орны нэг болоод байсан. Харин 2014 онд бодлогын орон зай ялимгүй нэмэгджээ. Гэхдээ энэхүү олон улсын харьцуулалтыг Дэлхийн банкны статистик мэдээлэлд голлон тулгуурлаж тооцсон тул Монгол улсын бодлогын индексийн утга өмнөх 3.1 хэсэгт, үндэсний статистикт тулгуурлаж хийсэн тооцооноос нэлээд доогуур гарч байгааг анхаарах шаардлагатай.

Зураг 5. Хөгжиж буй орнуудын бодлогын орон зайн индекс, 2009-2014 он





Эх сурвалж: (World Bank, 2015), (IMF, 2014), (BIS, 2014), Зарим орны Төв банкны Сар тутмын бюллетень

Зургаас харахад, сонгосон орнуудын эдийн засгийн бодлогын орон зай өмнөх онтой харьцуулахад 2009 онд дэлхийн санхүүгийн хямралын үед нэлэнхүйдээ хумигджээ (бодлогын орон зайн 2008-2014 оны дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 3-н Хүснэгт Х9-Х15-аас харна уу). Сонгосон орнуудын ихэнхид инфляци тухайн үед эрс буурч, зээлийн бодит хүү нэмэгдсэн боловч төсвийн алдагдал ихээр нэмэгдэж, үндэсний валютын ханш суларсан нь үүнд голлон нөлөөлсөн байна. Харин 2010 оноос эдгээр орны бодлогын орон зай эргээд сайжирч эхэлжээ. Гэхдээ хөгжиж буй олон орны бодлогын орон зай хямралаас өмнөх үеийн түвшиндээ эргэж очоогүй, хязгаарлагдмал хэвээр үлдсэн юм. Эдгээр орны төсвийн тэнцэл сайжирсан боловч эдийн засгийн халалтын улмаас инфляци эргээд өсч, бодит хүү буурсан нь үүнд нөлөөлж байна.

2012 онд бодлогын орон зай маш их нээлттэй байсан орнуудынх 2013 онд нэлэнхүйдээ бага зэрэг хумигдаж, харин хэт их хязгаарлагдмал байсан орнуудынх бага зэрэг уужирчээ. Жишээлбэл, уул уурхайн экспорт ихтэй Чили, Азербайжан, Ботсвана, Перу, Орос, Австрали, Индонез зэрэг улсын бодлогын орон зай 10-20 нэгж хувиар хумигдсан байна. Мөн БНСУ, Хонконг, Филиппин зэрэг Азийн аж үйлдвэржсэн орнуудын бодлогын орон зай ч бага зэрэг хумигджээ. Харин 2012 онд бодлогын орон зай маш хязгаарлагмал байсан

Аргентин, Монгол, Энэтхэг зэрэг орны бодлогын орон зай сүүлийн хоёр жилийн хугацаанд нэлээд тэлжээ.

3.3. Түүхий эдийн үнийн уналт ба хөгжиж буй орнуудын бодлогын орон зай

Арваад жил үргэлжилсэн түүхий эдийн үнийн өсөлт 2014 оны дундаас хойш тасралтгүй буурч байна. Түүхий эдийн үнийн бууралтаас гадна түүхий эдийн хамгийн том хэрэглэгч болох Хятадын эдийн засгийн өсөлт удааширч буй нь байгалийн баялгаа Хятадад экспортолдог Өмнөд Африк, Нигери, Бразил, Чили зэрэг оронд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь түүхий эдийн экспортоос шалтгаалдаг улс орнуудын мөнгө болон сангийн бодлогод томоохон цохилт болох юм. Зээлийн зэрэглэл тогтоодог Фитч (Fitch) компанийн үзэж буйгаар түүхий эдийн үнийн уналт төсөвт томоохон дарамт учруулж, улс орнуудын зээлээ эргэн төлөх чадавхийг сулруулж, зээлийн рейтингийг бууруулах ажээ. Тухайлбал, дэлхийн газрын тосны хамгийн их нөөцтэй улсуудын нэг болох Венесуэл өрөө төлж чадахгүйд хүрч, бусад томоохон экспортлогч болох Бразил, Норвегийн өсөлт удааширч, харин Оросын эдийн засаг 2015 онд 5 хувиар хумигдах төлөв гарчээ. Гэвч улс орнууд газрын тосны үнийн бууралтыг харилцан адилгүй даван туулж байгаа нь гадаад эдийн засгийн орчны хамаарал ба өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн бодлогоос нь шалтгаалж байна.

Байгалийн баялгийн экспортод түшиглэдэг Латин Америк, Африкийн хөгжиж буй орнуудад түүхий эдийн үнийн уналт томоохон сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Түүхий эдийн үнэ өндөр байсан сүүлийн жилүүдэд ихэнх хөгжиж буй орны засгийн газар нийгмийн халамжийн өгөөмөр хөтөлбөрүүдийг санаачилж (гол төлөв Латин Америкийн орнууд), дэд бүтцийн томоохон төслүүдийг (Африкийн улсууд) хэрэгжүүлжээ. Харин түүхий эдийн үнийн уналт эдгээр бодлогод томоохон сорилт болж байна.

Африк

Африкийн түүхий эд экспортолдог уламжлалт орнууд болох Ангол, Конго, Экваторын Гвиней, Нигери, Өмнөд Судан зэрэг оронд газрын тосны үнийн огцом бууралт хүнд цохилт болж байна. Учир нь эдгээр орон төсвийн нийт орлогынхоо 50-70 хувийг, экспортын орлогын 90 гаруй хувийг нефтийн орлогоор бүрдүүлдэг. Түүхийн эдийн үнэ өндөр байх үед төсвөө тэнцвэржүүлж чадаагүй олон орны хувьд байдал хүндрэх нь тодорхой. Сахарын Өмнөд Африкийн (Sub-Saharan Africa) хувьд 2015 оны эдийн засгийн өсөлтийн төлөв нь 4 хувь байгаа нь сүүлийн арав гаруй жилд байгаагүй доогуур үзүүлэлт юм.

Зэсийн экспортоос бүрэн хамааралтай Замби, нийт экспортын 60 гаруй хувийг төмөр болон алт эзэлдэг. Сахарын орчмын Африкийн улсуудын хувьд үндэсний

валютын ханш суларч, эдийн засгийн өсөлт саарчээ. Гэхдээ эдгээр улс газрын тосны үнийн бууралтаас хожих магадлалтай юм. Харин газрын тосны томоохон экспортлогч болох Нигерийн төсөв сүүлийн 15 жилд анх удаа алдагдалтай гарах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь исламын Боко Харам бүлэглэлтэй хийх тэмцэлд сөргөөр нөлөөлнө гэж үзэж байна.

Шинэ экспортлогч Гана улс онцгой муу жишээнд тооцогдож байна. Гана улс газрын тосноосоо ирээдүйд олох орлогыг хэт өндөр тооцоолж, түүнийгээ урьдчилан зарцуулж эхэлсэн учир 2011 оноос хойш төсвийн алдагдалд орж, засгийн газрын өр эрс нэмэгдэж, дотоодын валютын ханш 40 хувиар суларч, улмаар ОУВС-ийн тогтворжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ гаргажээ. Гэтэл Гана улсын газрын тосны үйлдвэрлэл 2020 оноос эхлэн буурах төлөвтэй байгааг Олон улсын эрчим хүчний агентлаг тооцоолжээ. Африкийн өөр зарим орон сүүлийн хэдэн жилд бизнесийн мөчлөгийн эсрэг нефтийн орлогын нөөц бүрдүүлж ирсэн. Гэхдээ Анголын 5 тэрбум ам.доллар бүхий баялгийн сан, Нигерийн 1 тэрбум ам.долларын нөөц болон нефтийн орлогын дансны илүүдэл хөрөнгө нь дэд бүтцийн хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэхэд хангалттай эсэх нь тодорхойгүй байна.

Латин Америк

2014 онд Латин Америкийн бүс ердөө 1.1 хувиар өссөн нь 2008-2009 оны санхүүгийн хямралаас хойшхи хамгийн бага үзүүлэлт бөгөөд бүс нутгийн томоохон эдийн засгийн бүс болох Аргентин (-0.2%), Венесуэл (-3.0%), Бразил (0.2%), Мексик (2.1%) зэрэг улсын өсөлт тааруу байсантай холбоотой юм. 2015 онд НҮБ-ын тооцоогоор тус бүс нутаг 2.2 хувиар өсөх төлөвтэй байна. Хэдийгээр ОУВС зэрэг олон улсын байгууллагууд Бразил 1.3%, Мексик 3.2%, Чили 3%, Колумб 4.3% өснө гэж таамаглаж байсан боловч түүхий эдийн үнийн сэргэлт ажиглагдахгүй байгаа учир ихэнх орны өсөлтийн таамаглалаа 0.5 пунктээр бууруулжээ.

Латин Америкийн бүс нутаг нэлэнхүйдээ хүндэвтэр байгаа боловч хамгийн сул эдийн засаг нь Аргентин ба Венесуэл хэвээр байна. Судлаач, ажиглагчдын үзэж байгаагаар Латин Америкийн орнуудыг эдийн засгийн нэгдмэл бүлэг гэж үзэж болохгүй юм. Байгалийн баялгаас хамаарч буй байдал, эдийн засгийн ерөнхий суурь, бодлогын хувьд эдгээр орон харилцан адилгүй байна.

1. *Эдийн засгийн хувьд тогтвортой орнууд.* Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн голчлон экспортолдог Мексик болон Төв Америкийн орнууд энэ ангилалд орж байна. Карибийн тэнгисийн эдгээр орон АНУ-ын эдийн засгаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд тус улсын эдийн засгийн сэргэлт тэдэнд өсөлтийн томоохон боломжийг нээж байна. Мексикийн хувьд хамгийн их экспортын орлого оруулдаг 10 бүтээгдэхүүний зөвхөн 2 нь түүхий эд

бөгөөд эдгээр нь газрын тос (нийт экспортын 13 хувь) ба алт (2.4 хувь) юм. Гэтэл Бразилийн 10 бүтээгдэхүүний 9 нь түүхий эд байна (төмрийн хүдэр, газрын тос, шар буурцаг, түүхий элсэн чихэр, кофе гэх мэт). Мексикийн нийт экспортын 70 орчим хувь нь АНУ-руу гардаг бөгөөд 1993 онд НАФТА-гийн гэрээ байгуулагдсанаас хойших 10 жилд энэхүү экспорт 603 хувиар өсчээ. Хэдийгээр АНУ-ын эдийн засаг сэргэж байгаа өнөө үед Мексикийн гадаад орчин таатай байгаа ч бодлогын хувьд хуримтлагдсан олон асуудал байсаар байна (Гиллен, 2015).

2. *Эрчим хүч ба түүхий эд экспортлогч орнууд.* Латин Америкийн дийлэнх орон энэ ангилалд ордог бөгөөд Хятадын эдийн засгаас ихээхэн хамаардаг. Одоогоор Бразилийн эдийн засаг үндсэндээ зогсонги байдалд орж, Чили зэрэг орны өсөлт саарах төлөвтэй байна.

Газар нутаг, байгалийн баялаг, эдийн засгийн чадавхиараа бүс нутагтаа тэргүүлж байгаа Бразил улсад олон сая өрхийн амьжиргаа сайжирч, дундаж давхаргад шилжин, нийгэм эдийн засгийн байдал сайжирч байсан бол газрын тосны үнийн огцом бууралтын нөлөөгөөр хөрөнгө оруулалт эрс багасч, дотоод валютын ханш суларч, инфляци өсчээ. Төрийн өмчийн Петролео Бразилейро (Петробраз) компанийн авилгын асуудал иргэдийг бухимдуулахын зэрэгцээ Бразилийн эрх баригчид улсынхаа эдийн засгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг энэ компанийн ашигт суурилан боловсруулсан нь эрсдэлд оруулаад байна.

Бразилийн хувьд 2015 он “их цэвэрлэгээний” жил байх төлөвтэй байна гэж Уортон их сургуулийн профессор Фелипе Монтейро дурджээ. Энэ улсын хүндрэл нь зөвхөн гадаад орчин бус, авилгад автагдсан улс төрийн тогтолцоо юм. Сүүлийн 7-8 жилд Бразил улс түүхий эдийн үнэ өндөр байсан тааламжтай хугацааг ашиглаж чадалгүй, төрийн хөшүүн зохицуулалт ба татварын бодлогын шинэчлэлийг хойшлуулсан нь өнөөгийн хүндрэлд хүргэжээ. Түүхий эдийн үнийн өнөөгийн бууралт нь өмнөх үеэс хуримтлагдаж ирсэн эдийн засгийн бүтцийн гажуудлуудыг засч, бодлогын өөрчлөлт хийх орон зайг хязгаарлаж байна. Гэсэн хэдий ч 2015 онд “их цэвэрлэгээ” хийхээс өөр аргагүй гэж судлаачид үзэж байна. Энэ нь төсвийн бодлогыг өөрчилж, татварыг нэмэгдүүлэх, татварын хөнгөлөлтийг цуцлах зэрэг олон нийтэд таалагдахгүй арга хэмжээ авахыг шаардана. Шинээр томилогдсон Сангийн сайд Хоаким Леви энэ бодлогыг хэрэгжүүлж чадвал үүний эерэг үр дүн 2016 оноос хойш л гарах юм. Гэхдээ зарим судлаач энэ асуудалд нэлээд болгоомжтой хандаж, үүний оронд урсгал тэнцэл алдагдалтай байгаа учраас гадаадын хөрөнгө оруулалтыг татах хэрэгтэй гэж зөвлөж байна.

4. *Хүнд байдалд орсон орнууд.* Боливи, Венесуэл, Аргентин зэрэг орон энэ ангилалд орох бөгөөд өөрсдөө ийм хүндрэлд орсон гэж болно. Эдгээр

оронд дэлхийн эдийн засгийн сөрөг нөлөөнөөс гадна дотооддоо явуулсан популист бодлогын уршгаар гадаадын хөрөнгө оруулалт болон гадаад худалдаа эрс буурч, гадаад валют ихээхэн хомсдож, үндэсний валютын ханш суларч, инфляцийг хөөрөгдөх нөхцөл бүрдээд байна.

Венесуэл улсын хувьд газрын тос 2012, 2013 онд нийт экспортын орлогын 96 хувийг эзэлж байсан бөгөөд газрын тосны үнийн уналтаас болж эдийн засаг гэнэтийн цочролд орж, улмаар улс төрийн хувьд хүндхэн байдалд ороод байна. Инфляци хоёр оронтой тоонд хүрч, өдөр тутмын хэрэглээний бараа хомсдон, дэлгүүрүүдэд хурууны хээний машин суурилуулсан бөгөөд энэхүү машины тусламжтайгаар иргэдэд хүнсний зүйлийг хязгаартайгаар олгож эхэлжээ. Газрын тосны үнэ ойрын хугацаанд сэргэхгүй бол эрх баригчид иргэдийн саналыг “худалдан авах” орлогогүй болж, засгийн газрын нэр хүнд эрс унаж, улс төрийн томоохон өөрчлөлт гарч болзошгүй байна. Газрын тосны үнэ 1 ам.доллараар буурах тутамд тус эдийн засаг 620-750 сая ам.долларын орлого алддаг ажээ (Barclays). Төсвийн алдагдал ДНБ-ий 17 хувьтай тэнцүү байгаа үед газрын тосны үнийн уналт тус улсыг бодлогын ямар ч орон зайгүй болгожээ. Улс орны хувьд өрөө төлж чадахгүйд хүрч, дампуурлаа зарлах магадлал өссөөр байна (Гиллен).

Эрх баригчид эдгээр эрсдэлийг багасгаж, бодлогын орон зайгаа тэлэх зарим арга хэмжээгавч байна. Тухайлбал, тус улсын ерөнхийлөгч өнгөрсөн оны сүүлээр улсын төсвийн зардлыг 20 хувиар бууруулахаа зарласан бол сүүлийн 12 жилийн турш хатуу барьж ирсэн дотоодын валютын албан ханшийг сулруулах арга хэмжээ авч эхэллээ. Албан ханш 1 ам.доллар нь 6.3 венесуэл боливар байхад хар захын ханш 190 боливар хүрээд байсан юм. Гэвч Венесуэлийн социалист засгийн газарт үзүүлэх иргэдийн дэмжлэг огцом буурч, улмаар засгийн газрын зүгээс эдийн засгийг эрүүлжүүлэх улс төрийн орон зай улам багассаар байна (Standard & Poor's).

Латин Америкт үүсээд буй дээрх хүндрэлийг Ситибанкны судлаач Гильермо Мондино “Венесуэл нь шинэ Зимбабве, Аргентин нь шинэ Венесуэл, Бразил нь шинэ Аргентин, Чили нь шинэ Бразил болсон байна” гэж дүгнэжээ.

Түүхий эдийн үнийн бууралт Латин Америкийн эдийн засагт маш их сөрөг нөлөөтэйгөөс гадна улс төр, нийгмийн тогтворгүй байдлыг дагуулах эрсдэлтэй юм. Учир нь эдгээр оронд баян хоосны ялгаа туйлын өндөр, популист засгийн газрууд нь ихэнхдээ байгалийн нөөцийн орлогод дулдуйдан эрх мэдлээ тогтоон барьж, төсвийн ихээхэн алдагдалтай, сул засаглалтай байдаг. Эдийн засгийн хүндрэл нь засаглалын гажуудал, улс төрийн авилга болон байгалийн нөөцийн алдаатай менежментийг ил болгох хандлагатай байна. Хэдийгээр зарим улсад

эрх баригчид төрийн дарангуйллын аргыг чухалчилж эхэлж байгаа ч эдийн засгийн хүндрэл нь олон орны хувьд нийгэм эдийн засгийн популист бодлогоос татгалзаж, уламжлалт консерватив бодлогоруу шилжихэд хүргэж байна.

4. ДҮГНЭЛТ

- Монголын эдийн засаг 2008-2009 оны хямралаас хойш 2014 он хүртэл хүчтэй халж, Хэт халалтын индекс байнга 60-аас дээш утгатай байсан бөгөөд эрчимтэй хөгжиж буй 30 оронтой харьцуулахад хамгийн эрсдэлтэй орны тоонд орж байв.
- Тэр үед хэт халалтын гол шалтгаан нь өндөр инфляци, урсгал тэнцлийн их алдагдал, зээлийн илүүдэл өсөлт, уул уурхайн салбарын тэлэлтээс үүдсэн эдийн засгийн хурдтай өсөлт болж байсан.
- Харин 2014, 2015 онд тус эдийн засаг огцом хөрчээ. Үүний гол шалтгаан нь зээлийн илүүдэл өсөлт буурсан, эдийн засгийн өсөлт саарсантай холбоотой.
- Эдийн засаг хүчтэй халж байсан үед харамсалтай нь Монголын эдийн засгийн бодлогын орон зай маш хязгаарлагдмал болсон байв. Тухайлбал, Бодлогын орон зайн индекс 2008-2009 оны хямралын үед тааруу байсан бөгөөд 2011 оны дунд үед бага зэрэг сайжирсныг эс тооцвол улам муудаж, 2013 онд уг индексийн утга 90 хүрсэн. Үүнийг 2012 оны байдлаар, эрчимтэй хөгжиж буй 30 орныхтой харьцуулахад хамгийн муу үзүүлэлт байв.
- 2014, 2015 онд Бодлогын орон зайн индекс аажим буурч 70 болсон ч хэт өндөр хэвээр байгаа юм.
